ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 23 өдөр Дугаар А/19 Шивээговь сум

Төрийн захиргааны албан хаагчдад
орон нутгийн нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 489 дүгээр тогтоол, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 242 дугаар тогтоол, 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 272 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/234 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдад 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутагт ажилласны нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувиар бодож олгосугай.

2.Төрийн захиргааны албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг дээр дурдсан хувиар сар бүр бодож олгохыг нягтлан бодогч (Б.Түвшинжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

D:\2023 oni barimt\TDarga\tushaal